



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЦЭНХЭРМАНДАЛ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ТӨВИЙН ЭРХЛЭГЧИЙН ТУШААЛ**

2024 оны 08 сарын 02 өдөр

Дугаар A/08

Модот

Хариуцлагатай жижүүр томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, Хөдөлмөрийн тухай хуулийн 97 дугаар зүйлийн 97.1.2 дах заалт эрүүл мэндийн сайдын 2020 оны А/36 тоот тушаал, Эрүүл мэндийн газрын даргын 2024 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 62 дугаар албан тоотыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сар шинийн барын өдрүүдэд ажиллах Эрүүл мэндийн төвийн хариуцлагатай жижүүр хийх эмч нарын хуваарийг нэгдүгээр хавсралтаар, сувилагч нарын хуваарийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.
2. Томилогдсон хариуцлагатай жижүүр Эрүүл мэндийн газрын хариуцлагатай жижүүртэй холбогдон мэдээгээ /АМ-36/, /АМ-33/ маягтын дагуу цаг хугацаанд нь өгөх, эмч, мэргэжилтнүүд гар утсаа байнга нээлттэй байлгахыг даалгасугай.
3. Энэхүү тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Чанарын багийн ахлагч (П.Хандармаа)-д үүрэг болгосугай.

ЭРХЛЭГЧ ИХ ЭМЧ



Г.ОЮУНБИЛЭГ